



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 10


Улаанбаатар хот

### Сургалтын нэг кредитийн төлбөр тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн бакалаврын сургалтад суралцагчдын сургалтын нэг кредитийн төлбөрийг хавсралтаар тогтоон мөрдсүгэй.
2. Магистрантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.5 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
3. Докторантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
4. Цагийн сургалтаар элсэн суралцаж буй оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.2 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
5. ШУТИС-д хэрэгжүүлж буй гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд гадаад хэл дээр заагдаж буй хичээлийн нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
6. ШУТИС-д суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тооцохдоо энэхүү тогтоолын 1-5 дахь заалтуудыг баримталсугай.
7. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Шинжлэх ухаан технологийн ахлах сургууль, ШУТИС-Коосен технологийн коллежийн 2018-2019 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 3,000,000 (гурван сая) төгрөгөөр, Дархан-Уул аймаг дахь ТИС лицей сургуулийн сургалтын төлбөрийг 1,200,000 (нэг сая хоёр зуун мянган) төгрөгөөр тогтоосугай.
8. Сургалтын нэг кредитийн төлбөрийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ШУТИС-ийн 2018 оны төсөвт шаардлагатай тодотголыг хийж, Удирдах зөвлөлд оруулж хэлэлцүүлэхийг захирал Б.Очирбат, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Б.Сүхбат нарт даалгасугай.

ДАРГА



Б.ГАНБАТ

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 12 -ны өдрийн 10 тоот тогтоолын хавсралт



ШУТИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилд мөрдөх бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөр (төгрөгөөр)

д/д	Сургуулийн нэр	Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ	
		2018 онд элсэн суралцагчид	2018 оноос өмнө элсэн суралцагчид
1	БАРИЛГА АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	74,900	73,000
2	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	78,900	76,900
3	ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ	74,900	73,000
4	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	67,600	65,900
5	МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ	74,900	73,000
6	МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	78,900	76,900
7	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	74,900	73,000
8	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ	68,900	67,200
9	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ	76,700	74,700
10	ГАДААД ХЭЛНИЙ ИНСТИТУТ	65,600	64,000
	<b>Дундаж</b>	<b>73,620</b>	<b>71,760</b>



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### ШУТИС-ийн 2017 оны санхүүгийн үйл ажиллагааг дүгнэх тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.5, Үндэсний аудитын газрын 201 оны 06/803 тоот аудитын гэрчилгээ, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.
2. ШУТИС-ийн 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан 2018 онд санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, санхүүгийн менежментийн шинэ тогтолцоог хэрэгжүүлэн ажиллахыг захирал Б.Очирбатад даалгасугай.

ДАРГА



Б.ГАНБАТ



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Нанотехнологийн аргаар ус үл нэвтэрдэг даавуу боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн талаар авах арга хэмжээний тухай

Удирдах зөвлөлийн дүрмийн 3.7.5 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн өмч, нанотехнологийн аргаар ус үл нэвтэрдэг даавуу боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр “Эрдэнэт хивс” ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээг дуусгавар болгосонд тооцсугай.
2. Нанотехнологийн аргаар ус үл нэвтэрдэг даавуу боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, орлогын эх үүсвэр бий болгох зорилгоор холбогдох хууль, журамд нийцүүлэн, инновацийн бүтээгдэхүүний туршилт судалгаа, үйлдвэрлэлийг ШУТИС-д явуулах үйл ажиллагааг зохион байгуулахыг ШУТИС-ийн захирал Б.Очирбат, Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Намнан, ҮТС-ийн захирал Ж.Туяацэцэг нарт даалгасугай.

ДАРГА



Б.ГАНБАТ